



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЛБАР ДАХЬ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИТ ТӨСЛҮҮД

А.ЧИНБАТ

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
НОГООН ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН ДАРГА

2025.03.13



АГУУЛГА

01

ОРХОН-ОНГИ, ХЭРЛЭН ТООНО
ТӨСӨЛ

02

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ ТӨР-
ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООТОЙ
САЙЖРУУЛАХ

03

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

04

АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

ОРХОН-ОНГИ ТӨСӨЛ

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ



ТЭЗҮ төсөв (2020 он): 1.9 тэрбум ₮
Нийт хөрөнгө оруулалт: 1.1 их наяд ₮
Эх үүсвэр: Улсын төсөв, бусад эх үүсвэр



Хугацаа: 2025-2032




Суурь
түвшин:

- ТЭЗҮ: - ТЭЗҮ (2020 он)
- Зураг төсөл: - 2022-2023 онд ТЭЗҮ, техникийн зураг төсөл хийгдсэн. (ӨАЗДТГ-ын санхүүжилтээр)
- Газар: - Шийдвэр гараагүй



Байршил: Өвөрхангай, Дундговь, Өмнөговь.



ТЭЗҮ-д тооцоолсноор 0,5 м3/сек буюу 500 л/сек усыг 700 мм голчтой 202 км урт дамжуулах хоолойгоор говийн бүсийн уул уурхайн төслүүдэд хүргэх боломжтой.

ХЭРЛЭН-ТООНО ТӨСӨЛ



ТЭЗҮ-ийн тодотгол төсөв : 3 сая.ам доллар

Эх үүсвэр: Оюу толгой ХХК



Хугацаа: 3-5 жил



Суурь
түвшин:

- ТЭЗҮ: - ТЭЗҮ (2014)
- ТЭЗҮ Тодотгол: - ТЭЗҮ Тодотгол (2024-2025)
- Зураг төсөл : - Төсөв батлагдаагүй
- Газар: - Шийдвэр гараагүй




Байршил: Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь аймаг



Хэнтий, Дэлгэрхаан, Тооно уулын дэргэд 2400 м урт, 40 м өндөр шороон боомт, 1.6 тэр.м3 усан сан, 6-7 МВт хүчин чадал бүхий УЦС байгуулна.



Хэрлэн-Тооно УЦС-Сайншанд хүртэл 235 км ус дамжуулах далд шугам хоолойг барина.




ГАДААД ОРЧНЫ АСУУДАЛ:

БНХАУ-тай хилийн усны
хэлэлцээр

Хэрлэн-Тооно төслийн хувьд 2014 оны судалгаагаар 4 м3/сек буюу 4000 л/сек усыг говь руу татах боломжтой бөгөөд ТЭЗҮ-ийн тодотголоор урьдчилсан төсөөллөөр усан санд 1,6 тэрбум.м3 ус цуглуулна гэж үзэхэд (50-127) сая.м3/жил усыг говь руу татах боломжтой бөгөөд энэ нь 1585 л/сек-4024 л/сек болно. Ингэснээр Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал, аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг чанар сайтай усаар бүрэн хангаж, Хэнтий аймагт 5000 га хүртэл усалгаатай тариалан эрхэлнэ. Хэрлэн гол дээр урсцын тохируулга хийснээр 5-10%-ийг ашиглахад л Сайншанд хот, аж үйлдвэрийн парк, олон сумдын төвийн хүн ам, зарим уул уурхайн үйлдвэрийн усны хэрэгцээг цэвэр цэнгэг усаар хангахаас гадна жилдээ 30 мянган.тн хүлэмжийн хийг бууруулна.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООТОЙ САЙЖРУУЛАХ

УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗӨВШӨӨРӨГДСӨН



393 хог хаягдлын цэг



3811.6 га талбай



289 хүн амын суурьшлын хэтийн бүсийн
гадна /3.5 км/

Нарангийн энгэрийн хог
хаягдлын төвлөрсөн цэгт



“Хог ангилан ялгах байгууламжийн
үйлдвэр”-ийн ажлыг эхлүүлсэн




2025 онд
ашиглалтад
оруулна

Төв аймагт Аюултай хог
хаягдлын төвлөрсөн
байгууламж байгуулах
газрын асуудлыг ЗГ-ын
хурлаар шийдвэрлэсэн.
Концесс зарлаж байгууламж
барих ажил хүлээгдэж
байна.

Хог хаягдлын тухай хуульд
нэмэлт өөрчлөлт оруулахаар
төлөвлөж байна.

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ТҮР ХАДГАЛАХ АГУУЛАХЫН БАЙРШЛУУД



Баригдаж дууссан



Баригдахаар төлөвлөж буй




Баригдаж буй



Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН – ТӨЛӨВЛӨЛТ, ҮЕ ШАТУУД

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэн **1.5 тэрбум мод** тарихаар төлөвлөснөөс аймаг, нийслэлийн Засаг дарга нар **44.1% буюу 680 сая мод**, уул уурхайн томоохон 22 аж ахуйн нэгж **39.6% буюу 610 сая мод**, төрийн байгууллагууд **10.5 хувь 162.1 сая мод**, банк санхүүгийн байгууллагууд **5.8% буюу 88.6 сая мод** тарихаар гэрээ байгуулсан.




“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН – ХЭРЭГЖИЛТ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш **83.9** сая модыг шууд болон дүйцүүлэх хэлбэрээр тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж байна. Мод тарих төлөвлөгөөг тарьсан модны тоотой харьцуулан үзэхэд гүйцэтгэл **5.45** хувьтай байна.

Бодит тарьсан модны тоо: 61,011,353
Дүйцүүлэн тооцсон модны тоо: 22,962,042

Оюу толгой ХХК – 10.2 сая мод, Эрдэнэс Тавантолгой ХХК нь 12.7 сая мод тарих зардлыг дүйцүүлэн ойн салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж байна.



“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ – УУЛ УУРХАЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш **32.1** сая модыг шууд болон дүйцүүлэх хэлбэрээр тарьж, зохих арчилгаа, хамгааллын ажлыг гүйцэтгэж байна.

Оюу толгой ХХК, Эрдэнэс Тавантолгой ХХК нь хариуцлагын гэрээг хэрэгжүүлэн мод тарихаас гадна ойн салбарт шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж, гаргасан зардлыг тарьсан модоор дүйцүүлэх хэлбэрээр ажиллаж байна.



“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ – УУЛ УУРХАЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮД

№	Санамж бичиг байгуулсан ААН-ийн нэр	Мод тарих амлалт	2030 он хүртэл төлөвлөгөө гаргасан эсэх	
			Төлөвлөгөө	Төсөв
1	“Эрдэнэс таван толгой” ХК	180,000,000	1	2,091,000,000,000.00
2	“Оюу толгой” ХХК	100,000,000	1	-
3	“Болдтөмөр Ерөө Гол” ХХК	100,000,000	1	-
4	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	100,000,000	1	-
5	“Энержи ресурс” ХХК	40,000,000	1	702,622,616,000.00
6	“Өсөх зоос” ХХК	30,000,000	-	-
7	“Саусгоби сэндс” ХХК	15,000,000	1	59,900,000,000.00
8	“Степ голд” ХХК	10,000,000	-	50,000,000,000.00
9	“Таван толгой” ХХК	6,000,000	-	-
10	“Бадрах энерги” ХХК	5,000,000	1	-
11	“Эрдэнэс Монгол” ХХК	5,000,000	-	-
12	“Бороо гоулд” ХХК	3,000,000	1	2,000,000,000.00
13	“Эрдэнэс силвер ресурс” ХХК	3,000,000	-	-
14	“Бүрдэл майнинг” ХХК	2,500,000	-	-
15	“Алтайн хүдэр” ХХК	2,500,000	-	-
16	“Монголросцветмет” ТӨҮГ	2,000,000	1	9,273,000,000.00
17	“Монполимет групп”	1,000,000	1	-
18	“Багануур” ХК	1,000,000	-	-
19	“МоЭнко” ХХК	1,000,000.00	1	9,500,000,000.00
20	“Платинум ланд” ХХК	1,000,000	1	-
21	“Шивээ овоо” ХК	500,000	1	5,000,000,000.00
ДҮН		608,500,000	13	2,929,295,616,000.00



Батламж авсан 21 байгууллагын 13 буюу 61.9 хувь нь санамж бичгийн хүрээнд 2030 хүртэл ажиллах төлөвлөгөөг боловсруулан баталсан бөгөөд тэдгээрийн 8 байгууллага нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн тооцооллыг хийсэн байна. Үлдсэн 8 компани буюу 38.1 хувь нь ямар нэгэн хөтөлбөр, төлөвлөгөөгүй, тухайн жилийн нөхцөл боломждоо тулгуурлан хийх ажлаа тодорхойлж байна.

ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ


Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/93 дугаар тушаал гарч байгаль хамгаалах чиглэлийн үйл ажиллагааг дэмжиж байна.

Үйл ажиллагаа

- Агаарын бохирдлыг бууруулах
- Ойжуулалт, ногоон байгууламж, тохижилт
- Хөрс хамгаалах, цөлжилтийг сааруулах
- Хог хаягдал
- Биологийн төрөл зүйлийн хамгаалал
- Засгийн газрын тусгай сангийн чиглэлээр

тус тус үйл ажиллагааг төлөвлөн тусгасан.



The background features a repeating pattern of stylized landscape elements in light green and yellow tones. These elements include suns with rays, clouds, various types of trees (some with green foliage, others with yellow leaves), and wavy lines representing water. The central text is overlaid on this pattern.

**АНХААРЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**